



Энэхүү аргачлалыг эхлээд 1990 оноос хойш Монгол Улсын зүгээс ХБНГУ-ын талаар явуулсан бодлого, түүний цаад учир шалтгааныг тайлбарлахад ашиглахыг оролдсон эл оролдлогодоо би нэгдсэн стратеги болон бусад дэд стратегийг хамруулсангүй. Харин бодлогын хэрэгжилт, үр дүн гэсэн хэсгийг дээр нь нэмж өгүүлэх болно.

## Монголын геополитикийн орчин, үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын ерөнхий зорилт

Геополитик гэдэг нь газар зүйн хүчин зүйлээр суурилсан гадаад улс төрийн бодлого, мөн түүнийг судлах шинжлэх ухаан<sup>1</sup> гэжээ. Энэ тодорхойлолтонд тусгагдсан газар зүйн хүчин зүйлс буюу геофактор гэдэгт газар зүйн байрлал, ундны цэвэр ус, газрын тос, байгалийн хий зэрэг түүхий эдэд хүрэх боломж, гарц, дэд бүтцийн гол зангилаа замд хүрэх гарц, технологийн хөгжил гэх мэт олон зүйлсийг хамруулдаг ажээ.<sup>2</sup>

Монголын хувьд авч үзвэл Орос, Хятад хоёр их гүрний дунд хавчуулагдан, тэдний эмзэг бүсэд, эх газрын гүнд түгжигдэн орших газарзүйн байрлал нь түүний геополитикийн орчинг тодорхойлох үндсэн хүчин зүйл болохын зэрэгцээ Монголын үндэсний язгуур ашиг сонирхлыг хэрэгжүүлэх арга замыг сонгоход шийдвэрлэх гол нөлөөтэй юм.

1991 онд социалист систем задарч, олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо ноёлж байсан Потсдамын эрин үе эцэс болсноор Монголын геополитикийн орчин эрс өөрчлөгдсөн.

Социализмын үед Монгол Улс нь ЗХУ-ын геополитикийн эрхшээлд орсноор социалист ангийн ашиг сонирхлыг дээдэлж, социалист хамтын нөхөрлөл буюу ЗХУ-ыг дагасан ганц тулгуурт бодлого явуулж байв. Тухайлбал, 1960-аад оны үеэс Зөвлөлт, Хятадын хооронд сөргөлдөөнт байдал бий болоход Монгол ч мөн Хятадтай

- 1 Д.Баярхүү, Евразийн геополитик, олон улсын харилцаа, одоо ба ирээдүй, Улаанбаатар 2002, 25-р тал.
- 2 Andrea K.Riemer, Geopolitik-Strategie 2004, Theorie und Praxis, Wien 2005, S.54.

харилцаагаа зогсоож, нутаг дэвсгэртээ Зөвлөлтийн цэргийн ангийг байрлуулж, нэг талаас аюулгүй байдлаа хангаж байсан ч, нөгөө талаас үзэхэд Хятад, Орос хоёр их гүрний сэргөлдөөний "барьцаанд" нутаг дэвсгэрээ байлгаж байсан<sup>3</sup> нь хэзээ ч дүрэлзэн асч мэдэх дайны хөлд нэрвэгдэх аюулыг ямагт агуулсан тийм нөхцөлд БНМАУ оршин тогтнож байв.

Харин ЗХУ задран унаж, Монгол Улс социалист чиг баримжаанаас татгалзсанаар хойд их хөршийнхөө геополитикийн эрхшээлээс гарч, үндэсний ашиг сонирхлоо дээдэлсэн, бие даасан бодлого явуулах боломжтой болсон. Гэхдээ энэ нь Оросын геополитикийн орон зайн нөлөөллөөс гарсан гэсэн үг биш бөгөөд Монголын газарзүйн онцлог байрлал нь хоёр их хөршийнхөө геополитикийн нөлөөллөөс ангид байх боломжийг хэзээ ч олгохгүй болов уу. Энэ үед монголчууд социализмаар замнасан өнгөрсөн 70 жилийн түүхээ эргэн харж, ганцхан том сургамж авсан бөгөөд энэ нь газарзүйн хувьд өөрийн оршин тогтнож буй хавчигдмал орчноосоо үүдсэн улс төрийн хязгаарлагдмал орчиндоо нэмэлт таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд гадаад болон аюулгүйн бодлогын олон төрөл, олон тулгууртай, олон идентификацтай байх нь зүйтэй юм гэсэн бодлого ажээ.<sup>4</sup> Энэ нь ч тухайн үеийн зохих бичиг баримтад тусгалаа олсон байдаг.

Тухайлбал 1994 онд Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэнэ."<sup>5</sup> гэж заасан бол мөн

3 Ц.Гомбосүрэн, "Олон тулгуурт гадаад бодлого-үндэсний аюулгүй байдлын чухал хүчин зүйл", Стратеги судлал, Улаанбаатар 1(1998), 9-р тал.

4 "Умард Атлантын Гэрээний байгууллага, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага ба Монгол Улс" дугуй ширээний ярилцлага, Стратеги судлал, Улаанбаатар 2(2004), 93, 96-р тал.

5 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар

онд баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд "Монгол Улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь:

" ... улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн. Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сөргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна."<sup>6</sup>

гэжээ.

Энд Монголын үндэсний ашиг сонирхол, гадаад бодлого хоёрын хоорондын харилцан шүтэлцэл тодорхой харагдаж байна. Эдгээр хуулиудыг боловсруулан гаргах тэр үед Монгол Улсын Гадаад явдлын сайд асан Ц. Гомбосүрэн гуай Монголын гадаад бодлогын олон тулгуурын тухай хожим өгүүлэхдээ:

"Олон тулгуурт шинэ бодлогын үндэс нь улс төрийн бодлогод ангич байр сууринаас хандах үзлийг халж, үндэсний эрх ашгийг дээдлэх зарчмыг тулгын чулуу болгон тунхагласан явдал юм. Чухамхүү ийм байр сууринаас Монгол Улсын өнөөгийн гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийг тулгуур гэж заншиж байна. Тулгуур гэж томъёолсны цаана гадаад бодлогын чиглэл бүхэн суурьтай буюу бодит хэмжүүртэй байх ёстой, тэдгээрийн нийлэх уулзвар нь Монгол Улсын үндэсний эрх ашиг байх ёстой гэсэн санаа буй. Хоёр хөрштэй харилцах бодлого, өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцах бодлого, Азийн бодлого, олон улсын байгууллагатай харилцах бодлого, хуучин социалист гэгдэж байсан улсуудтай харилцах бодлого, хөгжиж байгаа улсуудтай харилцах бодлого гэсэн зургаан үндсэн тулгуурыг Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон билээ. Гадаад бодлогын энд дурдсан

---

сарын 30, Төрийн мэдээлэл, Улаанбаатар 9(1994), 781-р тал.

6 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар сарын 30, Төрийн мэдээлэл, Улаанбаатар 9(1994), 805-806-р тал.

тулгуур зорилтууд байнгын шинжтэй боловч орон зай, цаг хугацаа болон бусад тодорхой хүчин зүйлээс хамааран тухайн үед зарим чиглэлүүдэд онцгой ач холбогдол өгч товойлгон тавьж байх шаардлагатай нь зүйн хэрэг. Энэ нь бусад чиглэлүүдийг бүрмөсөн орхигдуулж болно гэсэн үг биш. Ардчилал, шинэчлэлийн жилүүдэд хоёр хөрштэй болон өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцах бодлогод дээрх чиглэлүүдийн дотроос үнэхээр тэргүүлэх ач холбогдол агч, төр засгийн гадаад бодлогын гол анхаарал үүнд чиглэж ирсэн, одоо ч чиглэж байгаа.”<sup>7</sup> гэжээ.

Үүнээс үзэхэд 1990-ээд оноос хойш үед Монгол Улсын зүгээс АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй ойр дотно харилцааг хөгжүүлэх явдалд онцгой ач холбогдол өгч байсан нь гуравдагч бусад орны бодит сонирхол буюу нөлөөг өөртөө бий болгох замаар өөрийн газар байрлалаас өгөгдөлтэй улс төрийн хязгаарлагдмал орчныг даван туулах, хөрш хоёр орныхоо геополитикийн бүслэлтийн нөлөөг сааруулж, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа хангах гэсэн зорилгыг агуулж байна. Магадгүй энэ зорилгодоо хүрэхийн тулд АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө дорнын өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгох,<sup>8</sup> тэдгээртэй харилцан ашигтай хамтран ажиллагааг хөгжүүлэх,<sup>9</sup> гурав дахь

7 Ц. Гомбосүрэн, “Олон тулгуурт гадаад бодлого-үндэсний аюулгүй байдлын чухал хүчин зүйл”, Стратеги судлал, Улаанбаатар 1(1998), 9-10-р тал.

8 1994 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд гадаад бодлогын хоёр дахь чиглэлийн орнуудтай хамтран ажиллахдаа тэдний эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохих түвшинд хүргэх бодлого баримтлах тухай заасан байдаг.

9 Монгол Улсын 1990 оноос хойших үе үеийн Засгийн газруудын мөрийн хөтөлбөрт өндөр хөгжилтэй орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай заасан байна. Тухайлбал, 1990 оны 7-р сард ардчилсан шалгуураар анх удаа явуулсан сонгуулийн үр дүнд бүрэлдэн бий болсон шинэ Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд “Өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүхий л бололцоог ашиглахыг эрмэлзэнэ.” гэсэн бол УИХ-ын ээлжит гурав дахь удаагийн сонгуулийн үр дүнд 2000 онд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Монгол Улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг хангахад Европын орнуудтай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой гэж үзэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” хэмээн заасан байна.

түнш буюу гурав дахь хөрш,<sup>10</sup> иж бүрэн түншлэлийн<sup>11</sup> хэмжээнд хамтран ажиллах гэсэн ойлголтууд Монголын гадаад бодлогод шил шилээ даран бий болсон бололтой.

Гэвч эдгээр ойлголтуудыг онолын үндэслэлтэйгээр нэг мөр тайлбарлаж, нарийн тодорхойлсон явдал одоогоор алга байна. Жишээлбэл, гурав дахь хөрш болон гурав дахь түнш гэдэг хоёр ойлголтын хооронд ямар нэгэн зааг ялгаагүйгээр хольж хэрэглэж буйгаас гадна зарим нь "гурав дахь хөрш гэдэг бол НҮБ" гэж байхад зарим нь "хоёр хөршөөс бусад нь" зарим нь "гурав дахь хөрш гэдэг бол гадаад бодлогын хоёрдугаар чиглэлд буй өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнууд" гэж тайлбарладаг байна. Ерөнхий сайд Н.Энхбаяр 2002 онд "Иж бүрэн түншлэл" гэдэг ойлголтын хүрээнд харилцаа, хамтын ажиллагаагаа бүх салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг сонирхож байгаа эрмэлзлээ бид ухаардаг<sup>12</sup> хэмээн нэг удаа тодорхойлсон байх агаад мөн яг ийм санаа 2004 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна.<sup>13</sup>

- 10 Мөнхийн хоёр хөрштэй Монголын хувьд АНУ нь гурав дахь хөршийн зиндаанд байж болох тухай санааг анхлан АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкер 1990 оны 8-р сард БНМАУ-д айлчлахдаа илэрхийлсэн хэмээн Гадаад явдлын сайд асан Ц.Гомбосүрэн гуай Монгол Улсын ХХ зууны гадаад бодлогын түүхэн тойм номондоо дурдсан байдаг. Гэхдээ Монгол-Америкийн энэ гурав дахь хөршийн хэмжээний түншлэл нь Америк-Орос-Хятадын харилцаанд ямар нэгэн хохирол учруулахгүй байх тийм төвшинд байх ёстой гэжээ. ("Умард Атлантын Гэрээний байгууллага, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага ба Монгол Улс" дугуй ширээний ярилцлага, Стратеги судлал, Улаанбаатар 2(2004), 93-р тал)
- 11 Монгол Улс анх АНУ-тай 1996 онд стратегийн иж бүрэн түншлэлийн хэмжээнд хамтран ажиллах болсноос хойш ийм түншлэлийг Япон, ХБНГУ, Турк, БНСУ зэрэг улстай хөгжүүлж байна.
- 12 Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№110, Монгол Улсын Ерөнхий сайд Н. Энхбаярын ХБНГУ-д хийсэн айлчлалын материал, 2002-IV/21-26, II хэсэг.
- 13 2004 оны УИХ-ын ээлжит 4 дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "АНУ, Япон, БНСУ, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, тэдний бодит сонирхлыг Монголд бий болгон тэдгээр оронтой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, "Мянганы сорилтын хөтөлбөр"-ийн хүрээнд тусламж авах чиглэлээр ажиллана. Мөн иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд эдгээр улс оронтой улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт бүх талын харилцааг идэвхжүүлэн өргөжүүлнэ. Худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана." гэжээ.

Энэ бүгдээс өнгөц дүгнэж үзэхэд, Монгол Улсын хувьд гурав дахь хөрш гэдэг нь Монголын газар зүйн түгжигдмэл байдлаас үүдэн гарах сөрөг нөлөөллийг багасгахад хувь нэмрээ байнга оруулж буй улс хэмээн тодорхойлж болох ч юм шиг. Аливаа гуравдагч улс нь Монголд тодорхой бодит сонирхолтой байж, харилцан ашигтай хамтран ажилласны дүнд л урт удаан хугацаанд хөршийн ёсоор жинхэнэ утгаараа түншлэх боломжтой юм. Харин түүний оруулж буй хувь нэмэр байнга бус байх аваас гурав дахь түнш гэвэл зохилтой мэт. Иймд Монголын гадаад бодлогын үзэл баримтлалд эхний чиглэл (тулгуур) болсон хоёр хөрш орноос бусад бүх тулгуурын субъектууд гурав дахь хөрш эсвэл түнш гэсэн ангилалд багтах боломжтой юм шиг. Гэвч үүнийг нарийн тодорхойлохын тулд гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

Үүнээс гадна дээрх өндөр хөгжилтэй орнуудтай харилцах 1990-ээд оноос хойших үеийн харилцаанд тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэлийн нэг болоход гол нөлөө үзүүлсэн дотоод хүчин зүйлсэд Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн, 1990-1994 онд Монголд эдийн засгийн огцом уналт нүүрлэсэн явдал гарцаагүй орно.

### Монгол Улсын зүгээс ХБНГУ-ын талаар явуулж буй бодлого

Монгол Улсын зүгээс ХБНГУ-ын талаар 1990 оноос хойшид явуулж буй бодлого нь энэ үед Монгол Улсаас өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ажиллах тухайд баримтлан явуулж буй ерөнхий гадаад бодлогын хүрээнд захирагдан явагджээ. Монголын талаас ХБНГУ-ын бодит сонирхлыг ялангуяа эдийн засгийн бодит сонирхлыг өөртөө бий болгохын тулд харилцан ашигтай хамтран ажиллахыг 1990-ээд оноос хойш байнга өргөмжлэх хандлага ажиглагдаж байгаа нь ХБНГУ-ыг цаашид гурав дахь хөршөө болгох сонирхолтой байдгийн нэг илрэл юм.

1990-ээд оны эхэн үеийн хоёр талын томоохон хэмжээний айлчлалын үеэр тухайлбал ХБНГУ-ын Бундестагийн Дэд Ерөнхийлөгч Д. Ю. Кроненбергийн Монгол Улсад 1991 онд,

ХБНГУ-ын Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд К. Д. Шпрангерын Монгол Улсад 1992 онд, УИХ-ын дарга Н. Багабандийн ХБНГУ-д 1993 онд, Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатын ХБНГУ-д 1995 онд тус тус хийсэн айлчлалын үеэр илэрхийлсэн Монголын талын байр суурийг нэгтгэж үзвэл, тухайн үеийн бодит аргагүй байдлаас үүдэн манай тал голдуу тусламж дэмжлэг хүссэн хэлбэртэй байгаа ч цаашдаа хоёр талын харилцааг харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хөгжүүлэх ёстой бөгөөд тухайлбал Монгол орны эрдэс баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боломжийг Германы капитал, хөрөнгө оруулалт хийгээд тэргүүний техник, технологи, менежментийг хамтатган бодож үзвэл харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой гэж үзэж байжээ.<sup>14</sup> Үүнээс үзэхэд хэрэв Германы тал Монголын эрдэс баялгийн томоохон ордыг ашиглах, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд байгуулахад ихээхэн хөрөнгө оруулалт хийх аваас тэр нь Монгол дахь Германы бодит сонирхлын нэг бүрдэл хэсэг болж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх гэсэн төсөөлөл надад төрж байна.

Монгол Улсаас ХБНГУ-д чиглэсэн гурав дахь хөршийн бодлогын нэг илрэл гэж хэлж болохуйц зүйл бол Монголын тал 2002 оноос хойш ХБНГУ-тай иж бүрэн түншлэлийг хөгжүүлэхийг зорих болсон явдал юм. 2002 онд Ерөнхий сайд Н. Энхбаяр ХБНГУ-д айлчлах үедээ

“ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Роман Херцог хэдэн жилийн өмнө манай оронд айлчлахдаа хоёр орны харилцааг чин сэтгэлийн итгэмжилсэн харилцаа хэмээн тодорхойлсон юм аа. Бид хоёр орны энэхүү итгэмжилсэн сайн харилцааг XXI зуунд чиглүүлэн иж бүрэн түншлэлийн харилцаа болгон хөгжүүлж гүнзгийрүүлэхийг зорьж байна. ... Иж бүрэн түншлэл гэдэг ойлголтын хүрээнд харилцаа,

14 Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х.Н№50, Монгол-Германы улс төрийн харилцаа 1992 он; Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х.Н№60, Монгол-Германы улс төрийн харилцаа 1993 (Нэгдүгээр хэсэг); Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х.Н№45, БНМАУ, ХБНГУ-ын соёлын харилцаа 1988-1990; Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№76, Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатын ХБНГУ-д хийсэн айлчлал, 1995 он.

хамтын ажиллагаагаа бүх салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийг сонирхож байгаа эрмэлзлээ бид ухаардаг.”<sup>15</sup>

хэмээн мэдэгдсэнээр хоёр талын харилцааг иж бүрэн түншлэлд хүргэх шинэ зорилт нэмэгдэх болсон. Ийм түншлэлийн тухай санааг 1995 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат ХБНГУ-д айлчлах үедээ анх илэрхийлж, “Монгол, Германы харилцааг бүхий л салбарт зүйл бүрээр хөгжүүлэх сонирхолтой.”<sup>16</sup> байдгаа дурдсан байдаг.

### Бодлогын хэрэгжилт

Монгол Улсын зүгээс ХБНГУ-ын талаар явуулсан гурав дахь хөршийн бодлого, иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх зорилтыг Германы тал албан ёсоор хүлээн зөвшөөрч, хамтран хэрэгжүүлэхэд бэлэн буйгаа 2006 онд илэрхийлсэн<sup>17</sup> явдал бол манай гадаад бодлого зохих үр дүнд хүрч буйг илтгэж байна.

Иж бүрэн түншлэлийг бүх салбарт хамтран ажиллах явдал хэмээн ойлговол, өнөөгийн бодит үр дүнгээс харахад Монгол Улс, ХБНГУ-ын хооронд улс төр, парламент, батлан хамгаалах, эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрх зүй, байгаль хамгаалал, эрүүл мэнд, залуучууд, спорт, хэвлэл мэдээлэл гээд олон салбарт хамтын ажиллагаа хөгжиж буй тул хоёр орны хооронд иж бүрэн түншлэл тогтжээ гэж үзэх үндэстэй юм.

15 Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№110, Монгол Улсын Ерөнхий сайд Н. Энхбаярын ХБНГУ-д хийсэн айлчлалын материал, 2002-IV/21-26, II хэсэг.

16 Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№110, Монгол Улсын Ерөнхий сайд Н. Энхбаярын ХБНГУ-д хийсэн айлчлалын материал, 2002-IV/21-26, II хэсэг.

17 2006 оны 4-р сарын 3-4-ний өдрүүдэд Монгол Улс, ХБНГУ-ын Гадаад Хэргийн Яамд хоорондын зөвлөлдөх уулзалт болж, үүнд Монгол-Германы харилцаа бүхий л салбарт эрчимтэй хөгжиж буйг үндэслэн хоёр талын хооронд иж бүрэн түншлэлийн харилцаа тогтсон гэж үзсэний зэрэгцээ Германы тал Монгол Улсын гурав дахь хөршийн бодлогыг сонирхон, Монгол Улстай гурав дахь хөршийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд бэлэн бийгээд мэдэгдсэн байна. <http://www.mongolia-foreign-policy.net/latestbig.php?id=107>

Гэхдээ миний ойлгож буйгаар Монгол Улсад хамгийн их хөрөнгө оруулж буй гадаадын 20 аж ахуйн нэгжийн жагсаалтад ХБНГУ-ын компаниуд ордоггүй хэвээр байгаа төдийгүй манай талын чухалчлан үздэг уул уурхайн салбарт ч Германы хөрөнгө оруулалт бараг орж ирээгүй байгаа өнөөгийн нөхцөлд ХБНГУ-ын эдийн засгийн бодит сонирхлыг өөртөө бий болгож, энэ утгаараа харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж байна гэж хэлэхэд эргэлзээтэй юм. Магадгүй иймэрхүү сонирхол ХБНГУ-д тодорхой хэмжээнд төлөвшин бий болж, бодлогын төвшинд илэрч буй нь энэ байж болох юм.

### Хамтын ажиллагааны бодит үр дүн

Гурав дахь хөршийн үндсэн бодлогыг хэрэгжүүлэх явцдаа Монгол Улс нь тухайн цаг үеийн зорилт буюу 1990-ээд оны эхэн хагасын эдийн засгийн уналт болон шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахын тулд ХБНГУ-аас дэмжлэг тусламж авах асуудалд илүүтэй анхаарч байжээ. Иймд 1990 оноос хойших үеийн хоёр талын хамтын ажиллагааны бодит үр дүнг нэгтгэн үзэхэд манай тал тусламж, дэмжлэг авах тал уруугаа ихээхэн хэлбийсэн байдал харагдаж байна. Үүнд жишээ болгож доорх хэдхэн салбарыг энэ удаад авч үзлээ.

**1990-ээд оны эхэн хагас үеийн Монголын эдийн засгийн байдлыг тоогоор илэрхийлбэл**

Үзүүлэлтийн нэр	1989	1990	1991	1992	1993	1994
Эдийн засгийн өсөлт (%)	4,2	-2,5	-9,2	-9,5	-3	2,3
Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн өсөлт		-0,3	-13,1	-11,5	-10,6	-2,7
Хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлт		-2	-5,1	-4	-7,1	7,1
Инфляц (%)	-	-	152,4	325,5	183	66,3
Гадаад худалдааны тэнцэл						

(Mio \$)	1684,5	363,3	- 12,9	- 29,9	3,6	97,7
Экспорт (Mio US \$)	721,5	660,7	348	388,4	382,6	356,1
Импорт (Mio US \$)	963,0	924	360,9	418,3	349	258,4
Гадаадын тусламж (Mio US \$)			313,7	236,8	234,4	167,4
Валютын нөөц (Mio US\$)			49,3	20,5	4,6	27,2

Эх сурвалж: Үнэн, 1997.08.16-19, 2-р нүүр; 1999.02.11-12, 7-р нүүр.

### Улс төрийн харилцаа

- 1990 онд тус хоёр улс Улаанбаатар, Бонн хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээн ажиллуулсан. Тухайн үед Монгол Улс нийслэл Бонн хотод Элчин сайдын яамаа нээсний зэрэгцээ Берлин дэхь хуучин байраа салбарын статустайгаар авч үлдсэн байв.
- 1990-2006 онд Монголын Ерөнхийлөгч 2 удаа, УИХ-ын дарга 3 удаа, УИХ-ын Дэд дарга 3 удаа, Ерөнхий сайд 3 удаа, Гадаад хэргийн сайд 3 удаа ХБНГУ-д, харин Монгол Улсад Холбооны Ерөнхийлөгч 1 удаа, Холбооны Бундестагийн Ерөнхийлөгч 1 удаа, Холбооны Бундестагийн Дэд Ерөнхийлөгч 4 удаа, Холбооны Дэд канцлер буюу Гадаад хэргийн сайд 1 удаа тус тус харилцан айлчилсан.
- 1994 онд Монголын тал Гадаад бодлогын үзэл баримтлалдаа, 2002 онд Германы тал Холбооны Засгийн газраас Зүүн Азийн орнуудын талаар баримтлах журамд тус тус харилцан явуулах гадаад бодлогын үндсийг тодорхойлсон байна.
- "Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай тунхаглал"-ыг 1995 онд байгуулсан.
- Хоёр талын Гадаад хэргийн яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулахыг зорьж байна.
- Монгол тал доорх асуудалд улс төрийн дэмжлэг үзүүлэхийг Германы талаас хүссэнээс өнөөдөр эргэн харахад асуудлын

нэлээд нь хэдийнээ Монголд нааштайгаар шийдэгдсэн байна. Тухайлбал:

- 1991 оны 7 сард Лондон хотноо болсон "Долоо"-гийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичигт Монголын өөрчлөлт, шинэчлэлтийг цаашид дэмжих тухай санаа дэвшүүлэхийг 1991 онд,
- Монголыг дэмжиж КОКОМ-ийн хязгаарлалтаас гаргах талаар хүчин чармайлт тавихыг 1992 онд,
- Европын Холбооны гол орон болохын хувьд Европын Холбооны хүрээнд Монголын сонирхлыг дэмжих, тодруулбал ТАСИС хөтөлбөрийг өргөтгөх, Европын Холбооны элчин сайдыг Монголд суулгах, АСЕАН-Европын холбооны яриа хэлэлцээ, хамтарсан үйл ажиллагаанд манай улс оролцох зэрэг чиглэлээр манай санаачилга үйл ажиллагааг дэмжихийг 1996 онд,
- Ази-Европын Дээд хэмжээний уулзалтанд Монголын тал ажиглагчаар оролцох хүсэлтэй байдаг бөгөөд ХБНГУ манай энэхүү хүсэлтийг ойлгон дэмжихийг 1998 онд,
- Монгол Улс НАТО-тай хүн сургах, мэдээлэл солилцох болон техникийн хамтын ажиллагааны зарим анхны алхмууд хийгдээд байсан бөгөөд манай талын энэхүү хэлбэрийн хамтын ажиллагааг НАТО-гийн гол орон болохын хувьд дэмжихийг 1998 онд тус тус ХБНГУ-ын талд албан ёсоор хүсэлт болгож байжээ.

1996 оноос хойш НҮБ-ын бүтэц, үйл ажиллагаанд шинэчлэлт хийх, Аюулгүйн Зөвлөлд ХБНГУ байнгын гишүүнээр элсэхийг дэмжиж буйгаа Монгол Улс илэрхийлсээр иржээ. ХБНГУ-ын зүгээс газрын минийг илрүүлэн устгах асуудалд дэлхийн нийтийн анхаарлыг хандуулах, зэвсгийн энэ төрлийг бүрмөсөн хориглох талаар тавьж буй өөрийн чармайлтыг Монгол Улс өргөнөөр дэмжихийг 1996 онд, Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэгжүүлж, хүний эрхийг хамгаалах асуудал зөрчигдөж буйг 1999 онд анхаарахыг тус тус Монголын талаас хүссэн байна.

### Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа

- 1994 онд хоёр тал цэргийн албан ёсны харилцаа тогтоож, 1994 оны 2-р сарын 22-ноос ХБНГУ-аас Монгол Улсад (хавсран)

- суух цэргийн атташе, харин 1996 оны 5-р сарын 13-наас Монгол Улсаас ХБНГУ-д (хавсран) суух цэргийн атташе тус тус томилогдон ажиллах болсон<sup>18</sup>.
- 1995 онд Холбооны Батлан хамгаалах яам дахь Парламентын төрийн нарийн бичгийн дарга Бернд Вильцийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр “Бундесверийн Цэргийн сургуульд Монголын цэргийн боловсон хүчнийг сургаж, цэргийн боловсролын салбарт тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, ХБНГУ-ын Батлан хамгаалах яам хоорондын гэрээ”, “Монгол Улс, ХБНГУ-ын Батлан хамгаалах яамдын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл”-д тус тус гарын үсэг зурсан байна<sup>19</sup>.
  - 1993-1996 онд нийт 4 удаа хуучин БНАГУ-ын армийн зэвсэглэлд байсан нөөцөөс 18 сая 122 мянган ДМ-ийн үнэ бүхий зүйлсийг Монголын цэргийн салбарт иргэний зориулалтаар хүмүүнлэгийн тусламж болгон үзүүлсэн байна<sup>20</sup>.
  - 1992-2004 онд ХБНГУ-ын Цэргийн Удирдлагын Академи, Бундесверийн Их сургууль, Хуурай замын цэргийн офицерын сургууль, Герман хэлний багшийн Их сургуульд батальон, рот, салааны захирагч, герман хэлний багшийн дамжаанд давхардсан тоогоор Монголын 92 цэргийн албан хаагч суралцсан ба 13 цэргийн албан хаагч суралцаж байсны зэрэгцээ Батлан Хамгаалах Их Сургуульд ХБНГУ-ын тусламжтайгаар герман хэлний иж бүрэн кабинетыг тоноглон ашиглалтанд оруулсан<sup>21</sup>.
  - 2000 оноос хойш хоёр талын Батлан хамгаалах яамдын хооронд зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулж, хамтын ажиллагааны механизмыг бий болгож чадсан.
  - 1990-ээд оны сүүлч үеэс хойш Монголын цэргийн болон Зэвсэгт хүчний байгуулалтын тулгамдсан асуудлаар богино хугацааны
- 18 А. Түвшинтөгс, “Монгол Улс, ХБНГУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын төлөв”, Удо Б. Баркманн, Л. Хайсандай, Монгол-Германы харилцаа, Өнгөрсөн үе, эдүгээ, хэтийн төлөв, Улаанбаатар 2004, 127-р тал.
- 19 Ш. Содномжамц, “Монголын офицеруудыг Германд сургана”, Ардын эрх, 1995.10.05, 2-р нүүр.
- 20 А. Түвшинтөгс, “Монгол Улс, ХБНГУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын төлөв”, Удо Б. Баркманн, Л. Хайсандай, Монгол-Германы харилцаа, Өнгөрсөн үе, эдүгээ, хэтийн төлөв, Улаанбаатар 2004, 127-р тал.
- 21 Мөн тэнд, 126-р тал.

- сургалт, семинарыг Германы талтай хамтран байнга зохион байгуулж байна.
- Зэвсэгт хүчинд ахлагчийн үүрэг роль улам бүр нэмэгдэж буй тул энэ талаар Германы зэвсэгт хүчний хуримтлуулсан туршлагаас суралцан өөрийн ахлагч бэлтгэх тогтолцоогоо шинэчлэхэд тусламж дэмжлэг үзүүлэхийг Монголын тал хүссэний дүнд Батлан Хамгаалах Их Сургуульд Ахлагч бэлтгэх төвийг бэхжүүлсэн.
  - Монголын талын хүсэлтээр НҮБ-ын Энхийг сахиулах сургалтын төвд энхийг сахиулах ажиллагааны ажиглагч бэлтгэх сургалт, семинарт хүн сургаж байна.
  - Америк-Германы хамтарсан Аюулгүй байдлын судалгааны Европын Маршалл төвд 2002 оноос эхлэн 2004 он хүртэлх дээрх төвийн 3 шатны сургалт, семинарт нийт 20 хүн хамрагдаад байна.
  - Монгол Улсын Зэвсэгт хүчний радио холбооны байнгын сүлжээг шинэчлэх төсөл, Зэвсэгт хүчний Клиникийн Төв Эмнэлгийн эмчилгээний зарим багаж, төхөөрөмжийг шинэчлэх төслийг ХБНГУ-тай хамтран хэрэгжүүлэх асуудал яригдаж байна.<sup>22</sup>

### Парламентын хамтын ажиллагаа

- Монгол Улсын Ардын Их Хуралд 1991 оны 3-р сард Монгол-Германы парламентын бүлэг анхлан байгуулагдсан бөгөөд харин ХБНГУ-ын Бундестагийн 1994 оны сонгуулийн дараа байгуулагдсан Герман-Төв Азийн парламентын бүлэгт Монгол Улс нь хамрагдах болжээ.
- 1992 оноос эхлэн хоёр орны парламентын гишүүд юуны өмнө байнгын давтамжтайгаар харилцан айлчилж буй бөгөөд энэ нь зөвхөн холбогдох парламентын бүлгээр хязгаарлагдахгүй төсөв, санхүү, эдийн засаг, эрх зүй, гадаад бодлого зэрэг гол байнгын хороодыг хамарч байна. 1992 оноос хойш ХБНГУ-д УИХ-ын дарга 3 удаа,<sup>23</sup> УИХ-ын Дэд дарга 3 удаа,<sup>24</sup> Монгол

22 А. Түвшинтөгс, "Монгол Улс, ХБНГУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын төлөв", Удо Б. Баркманн, Л. Хайсандай, Монгол-Германы харилцаа, Өнгөрсөн үе, эдүгээ, хэтийн төлөв, Улаанбаатар 2004, 128-р тал.

23 Januar 1993- N. Bagabandi, Oktober 1996- R. Gonchigdorj, April 1997- R. Gonchigdorj,

24 September 2001- J. Byambadorj, Februar 2002- J. Byambadorj, Dezember 2003-

Улсад Бундестагийн Ерөнхийлөгч 1 удаа,<sup>25</sup> Бундестагийн Дэд Ерөнхийлөгч 4 удаа<sup>26</sup> тус тус айлчилсан байна.

- Тодорхой хуулийн төслийг хэлэлцэхэд туршлага судлуулах эсвэл тодорхой зарим байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, холбоо тогтоолгох зорилгоор ХБНГУ-ын Конрад Аденауэрын Сан, Ханс Зайделын Сан, Фридрих Эбертийн Сан зэрэг улс төрийн сангууд болон Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг өөрийн хэрэгжүүлж буй төслийн шугамаар Монголын парламентын гишүүдийг ХБНГУ-д мэдээллийн айлчлал хийлгэдэг практик хоёр талын хамтын ажиллагаанд нэвтэрч байна.
- ХБНГУ холбооны бүтэцтэй байдаг нь хоёр талын парламентын хамтын ажиллагаанд зөвхөн Бундестаг төдийгүй муж улсуудын Ландтагтай хамтран ажиллах боломжийг олгож байна. Тодруулбал, Монгол Улс 1994 оноос хойш ХБНГУ-ын Нордрайн-Вестфален муж улсын Ландтаг болон түүний Тамгын газартай хамтран ажиллаж, 1995 оноос хойш УИХ-ын Тамгын газрын 2 ажилтанг 6 долоо хоногийн хугацаагаар тус мужийн парламентад дадлага хийх боломжийг олгосны зэрэгцээ хуулийн ном, сэтгүүл бэлэглэж байна.<sup>27</sup>

### Хөгжлийн хамтын ажиллагаа

- 1990 оны 11-р сарын Монгол Улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн Холбооны Канцлер Х. Коль-д захидал илгээж, санхүүгийн тусламж үзүүлэхийг хүссэний үр дүнд хоёр талын хөгжлийн хамтын ажиллагаа эхлэлээ тавьж, 1991 онд Улаанбаатар хотноо хоёр талын хөгжлийн хамтын ажиллагааны талаар Засгийн газар хоорондын хэлэлцээ явагдсаны үндсэн дээр 1991 онд Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 1992 онд Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр тус тус байгуулагдсан билээ. Үүнээс хойш хоёр талын томоохон айлчлалын үеэр Монголын

---

S. Tumor-Ochir,

25 Juli 2006- N. Lammert

26 September 1991- D. J. Cronenberg, Juli 1995- Burhardt Hirsch, April 1999- A. Vollmer, Juli 2003- A. Vollmer,

27 Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/НН№78, Монгол-Германы харилцаа 1995.

тал Германы талд тусалж дэмжиж буйд байнга талархахын зэрэгцээ ийм тусламж дэмжлэг нь цаашдаа ч Монголын хувьд ихээхэн чухал байгааг цохон тэмдэглэсээр иржээ. Хоёр талын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг 1991 онд (2 удаа), 1992 онд, 1993 онд (2 удаа), 1994 онд, 1995 онд (2 удаа), 1997, 1998, 2000, 2002, 2004 онуудад тус тус нэг удаа байгуулсан байна.

- ХБНГУ-ын Засгийн газрын даалгавраар хөгжлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд болох Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Германы Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны төлөөлөгчийн газар Улаанбаатар хотноо байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.
- Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд К.Д.Шпрангер 1992 онд, Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Парламентын төрийн нарийн бичгийн дарга Уши Айд 2002 онд Монгол Улсад айлчилсан.

#### ХБНГУ-аас Монгол Улсад үзүүлсэн хөгжлийн тусламж

	Санхүү- гийн тусламж	Техникийн тусламж /үндсэн чиглэлээр/	Дүн	Техникийн тусламж /бусад чиглэлээр/	Нийт дүн <sup>6</sup>
1991(сая ДМ)	15	9	24		
1992(сая ДМ)	10	5	15		
1993(сая ДМ)	14	11	25		
1994(сая ДМ)	17	11	28		
1995(сая ДМ)	12	13	25		
1996(сая ДМ)	15	14	29		
1997(сая ДМ)	15	15	30		
1998/1999 <sup>1</sup> (сая ДМ)	25+17 <sup>2</sup>	25+3 <sup>3</sup>	70		
2000-2001 (сая ДМ)	20+8 <sup>5</sup>	20+6 <sup>4</sup>	54		
2002/2003 (сая евро)	10	10+1 <sup>7</sup>	21		
2004/2005 (сая евро)	9+3 <sup>8</sup>	11+1 <sup>9</sup>	24		
2006/2007 (сая евро)	9	9,5	18,5		
Нийт 1991-2007 (сая евро)	123,20	99,99	223,19	30,3	253,49

- 6 Холбооны муж улсуудын эх сурвалжийг үл оролцуулан тооцсон мөнгөн дүн
- 1 1998 оноос эхлэн 2 жилээр амлах болсон.
- 2 Ерөнхийлөгч Херцогийн айлчлалын үеэр амласан: Харилцаа, холбоо II+III-т зориулж 17 сая ДМ
- 3 Ерөнхийлөгч Херцогийн айлчлалын үеэр амласан: Эдийн засгийн эрхийг түлхүү харгалзан эрх зүйн зөвлөлгөө өгөх төсөлд зориулж 3 сая ДМ
- 5 Засгийн газар хоорондын хэлэлцээний амлалтаас гадуурх амлалт 8 сая ДМ, "Сэргээгдэх эрчим хүч" төсөлд зориулсан тусгай амлалт (2001 он)
- 4 Засгийн газар хоорондын хэлэлцээний амлалтаас гадуур "Зуд" яаралтай тусламжийн хөтөлбөр 2 сая ДМ болон "Сэргээгдэх эрчим хүч" төсөлд зориулсан тусгай амлалт 4 сая ДМ (2000 он)
- 7 Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Парламентын төрийн нарийн бичгийн дарга У. Айдын айлчлалын үеэрх тусгай амлалт: хуулийн мэргэжилтнүүдийг давтан сургах төсөл, 1 сая евро
- 8 а) дэлхий нийтэд ач холбогдол бүхий арга хэмжээнд (эрчим хүчний үр ашигтай хэрэглээ) зориулсан тусгай хөрөнгө 3 сая евро (VE 2004), б) ХАС банкинд зээл олгоход зориулж 3,0 сая (VE 2005), в) хувийн байшин барихад дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн хөтөлбөр 3,3 сая (VE 2005)
- 9 Дэлхий нийтэд ач холбогдол бүхий арга хэмжээнд зориулсан тусгай хөрөнгө (ДОХ-той тэмцэх арга хэмжээ)

Эх сурвалж: 1991-2005 оны мэдээг ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамнаас, 2006-2007 оны мэдээг [www.bfai.de](http://www.bfai.de) сайтаас авч ашиглав.

## МУ, ХБНГУ-ын хөгжлийн хамтын ажиллагааны үе шатууд

	Нэгдүгээр үе, 1991-1992	Хоёрдугаар үе, 1993-2001	Гуравдугаар үе, 2002 оноос хойш
Төслийн өснөлт	1991-1992 онд хоёр талын хөгжлийн хамтын ажиллагаа Монголд хурцаар тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд илүү чиглэгдэж байсан гэж хэлж болохоор байна. Тухайлбал, 1991 онд үзүүлсэн нийт хөгжлийн тусламжийн (24 сая ДМ) дөрөвний нэгийг Улаанбаатар хотын хүнсний өдөр тутмын хангамжийг тасалдуулахгүйн тулд эдийн засгийн харьцангуй үр ашиг муутай төслүүдэд <sup>28</sup> зарцуулсан байна. Гэвч энэ нь нэг талаар Монголд хуучин БНАГУ-ын үеэс уламжлагдсан "хөгжлийн тусламжийн балгас" үлдээхгүй байх нь зүйтэй гэсэн Германы бодлоготой <sup>29</sup> холбоотой юм.	Энэ үед хэрэгжүүлсэн төслүүд бараг бүх салбарыг хамарч байв. Жишээлбэл, эдийн засаг, хүрээлэн буй орчин, эрчим хүч, харилцаа холбоо, боловсрол, нийгэм, эрүүл мэнд г.м	Энэ үед бүх төслүүд зөвхөн дээр дурдсан хоёр үндсэн чиглэлд төвлөрч байна.
Төслийн төлөвлөлт	1991-1992 онд хэрэгжүүлсэн төслүүд нарийвчилсан төлөвлөгөөгүй, ихэвчлэн барааны тусламж хэлбэрээр хэрэгжиж байв. Энэ үед хэрэгжсэн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл"-ийг дараагийн үе шат буюу 1993-2005 онд хэрэгжүүлсэн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл"-тэй харьцуулж үзвэл том ялгаатай байна. Хэдийгээр эдгээр төсөл нь Монголын Жижиг, дунд үйлдвэрүүдэд зээл олгосноороо хоорондоо ижил боловч хоёр дахь үе шатанд хэрэгжсэн төсөл нь эрсдэлийг бууруулах арга хэмжээг хослуулснаараа илүү үр дүнтэй байсан билээ. Гэвч эхний үе шатанд ганц нэг сайн төлөвлөсөн төсөл байсныг дурдахгүй өнгөрч болохгүй.	Энэ үе шатанд төсөл тус бүрийн хувьд авч үзэхэд төлөвлөлт сайжирсан байна. Техникийн хамтын ажиллагааны төслүүдэд асуудлыг 3 төвшинд (бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зорилтот бүлэг) шийдвэрлэх бүтэц бий болсон нь ажиглагдаж байна. Харин санхүүгийн хамтын ажиллагааны төслүүдийн хувьд хөнгөлөлттэй зээлийг олгохдоо шаардагдах үйлчилгээг хавсран үзүүлэх болсон бөгөөд үүнийг ихэвчлэн нэмэлт болон дагалдах арга хэмжээний хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.	2002 оноос төслүүдийг хооронд нь уялдаатайгаар төлөвлөх болсноор төслүүдийн багц бий болж байна. Жишээлбэл бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Улиастайд ажил эрхлэлт, орлого олох боломжийг уялдаатайгаар төлөвлөх болсноор төслүүдийн багц бий болж байна. Жишээлбэл бүсийн тулгуур төвүүд болох Дархан-Уул, Улиастайд ажил эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх зорилгыг бие даасан 4 төсөл хамтран хэрэгжүүлж байна.

28 БНМАУ-ын Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№50, Монгол-Германы улс төрийн харилцаа 1992.

29 БНМАУ-ын Гадаад харилцааны Төв Архив, Ф№70, Х/Н№49, БНМАУ, аж-ын улс төрийн харилцаа 1991 он